



## News Release

# MERIT releases video showcasing environmental benefits of its drone mapping project

*New video highlights innovative work supporting sustainable economic and social development in Mongolia*

**Jan. 21, 2019** – The MERIT project in Mongolia has produced a video showcasing its innovative work in environmental drone mapping of the resource industry.

The drone mapping and related training, by CESO-WUSC's MERIT project, enables local governments to monitor and assess industry environmental impacts such as land use changes and ongoing reclamation efforts.

“Our work in innovative projects, such as the drone mapping training, not only allows for greater monitoring and transparency of the environmental impacts of the natural resource industry, it also builds capacity at the local level,” says MERIT Project Director Jennifer Adams.

The drone mapping project provides hands-on, train-the-trainer workshops by MERIT's Canadian Technical Advisors to local authorities, who are responsible for monitoring mineral resources, environment protection, and land-use management in Mongolia communities.

The training contributes to more open communication with communities regarding infrastructure development and conservation efforts, which can result in greater community engagement.

The training also builds capacity at the local level -- those trained are able to train others in remote locations and share information with central level agencies, resulting in long-term expertise for Mongolians.

The [new video](#) features breathtaking views of the Mongolian landscape and of ongoing land reclamation efforts.

MERIT also recently produced two additional videos, one focussing on a MERIT Technical Advisor [on assignment in Mongolia](#), and the other on MERIT's work in [gender mainstreaming](#) to ensure equitable access and benefit to project activities, resources and outcomes for women and men in Mongolia.



## News Release

### **About MERIT**

The MERIT (Mongolia Enhancing Resource Management through Institutional Transformation) project supports responsible resource management aimed at sustainable economic and social development to improve the livelihoods of communities in Mongolia. The project is a partnership between two Canadian non-profit organizations: CESO (Canadian Executive Service Organization); and WUSC (World University Service of Canada). MERIT is a multi-year project funded by Global Affairs Canada.

### **About Canadian Executive Service Organization (CESO)**

CESO is an international economic development engine growing sustainable, inclusive businesses, and strengthening government infrastructure. CESO deploys its experts to communities, partners, governments and people starting or growing their businesses around the world and in Canada. A not-for-profit organization since 1967, CESO's experts are volunteer advisors who devote their time and energy toward economic and social change in more than 500 assignments each year.

### **About WUSC**

World University Service of Canada is a non-profit organization dedicated to providing education, employment and empowerment opportunities for youth around the world.

We thank and gratefully acknowledges the financial support of Global Affairs Canada.

### **Contact**

Karin Seybold  
Communications Manager  
416-471-2600  
[kseybold@ceso-saco.com](mailto:kseybold@ceso-saco.com)

or

**David Brazeau**  
Director of Communications and Engagement  
416-294-5673  
[dbrazeau@ceso-saco.com](mailto:dbrazeau@ceso-saco.com)



**CESOSACO**  
STRONGER ECONOMIES. BETTER LIVES.



**WUSC EUMC**



## News Release

MERIT төсөл дрон зураглалыг байгаль орчинд хэрхэн үр өгөөжтэй ашиглах талаар танилцууллаа

*Энэхүү бичлэг нь Монгол Улсын нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжлийг дэмжихэд технологийн дэвшил чухал болохыг харуулсан байна.*

**2019 оны 1-р сарын 21** – Монгол Улсад хэрэгжиж буй MERIT төсөл эрдэс баялгийн салбарт дрон ашиглан газрын зураг боловсруулах талаар танилцуулга бүхий богино хэмжээний бичлэг хийлээ.

Канадын мэргэжлийн үйлчилгээний байгууллага болон Канадын дэлхийн их сургуулийн үйлчилгээний байгууллагуудын хамтран хэрэгжүүлдэг MERIT төслөөс явуулсан дрон зураглал боловсруулах болон түүнийг хэрхэн ашиглах талаарх сургалт нь орон нутгийн төрийн байгууллагуудад газар ашиглалтын байдал, нөхөн сэргээлтийн ажлын явц зэрэг тухайн салбарын үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг хянаж, үнэлэх явцыг хялбарчлах боломжийг олгосон.

MERIT төслийн захирал Женнифер Адамс “Дрон зураглалын сургалт зэрэг дэвшилтэт технологийг ашиглах чиглэлээр бидний хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа нь эрдэс баялгийн салбараас хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөллийг ил тод болгож, хяналт шалгалтын үр дүнг нэмэгдүүлээд зогсохгүй орон нутгийн хүний нөөцийг давхар чадавхжуулдаг” гэдгийг онцлов.

Дрон зураглал боловсруулах, ашиглах чадавхыг бий болгох ажлын хүрээнд MERIT төслийн Канад техникийн зөвлөхүүд Монгол Улсын байгалийн баялгийн хяналт, байгаль хамгаалал, газар ашиглалтын менежментийн чиг үүрэг бүхий орон нутгийн төрийн байгууллагын албан хаагчдад зориулан практикт суурилсан “Сургагч багш бэлтгэх сургалт”-ыг зохион байгуулсан.

Сургалт нь дэд бүтэц хөгжүүлэх, байгаль хамгаалах ажлын талаар ард иргэдтэй нээлтэй харилцах, мөн орон нутгийн иргэдийн ойлголтыг сайжруулах болон оролцоог нэмэгдүүлэхэд хувь нэмрээ оруулна.

Цаашид бэлтгэгдсэн сургагч багш нар нь алслагдсан орон нутагт дээрх сургалтыг зохион байгуулж, улмаар сумын түвшнээс төрийн захиргааны төв байгууллагуудтай шууд мэдээлэл солилцох чадвар бүхий урт хугацааны тогтвортой мэргэжлийн бүрэлдэхүүнтэй болох юм.

Уг бичлэгт Монголын газар нутгийн байдал, нөхөн сэргээлтийн ажлын явц зэрэг дүр зургийг гайхамшигтайгаар харуулсан.



**CESOSACO**  
STRONGER ECONOMIES. BETTER LIVES.



**WUSC EUMC**



## News Release

Үүнээс гадна, MERIT төслийн баг Монгол Улсад ирж ажилласан техникийн зөвлөхийн сэтгэгдэл болон эмэгтэй, эрэгтэй хүмүүс төслийн үйл ажиллагаанд тэгш оролцох, төслийн үр шимээс тэгш хүртэх боломжийг бүрдүүлэхийн тулд жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг бодлого төлөвлөлт, үйл ажиллагаанд тусгах чиглэлээр хийж буй ажлыг харуулсан хоёр төрлийн бичлэгийг хийгээд байна.

### **MERIT төслийн тухай**

MERIT (Монгол Улс: Институцийн өөрчлөлт хийх замаар эрдэс баялгийн менежментийг сайжруулах) төсөл нь төрийн байгууллагуудын менежментийг сайжруулах замаар Монголын олборлох салбарын нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжилд оруулж буй хувь нэмрийг нэмэгдүүлэх зорилготой. Тус төсөл нь Канадын мэргэжлийн үйлчилгээний байгууллага (КМҮБ) болон Канадын дэлхийн их сургуулийн үйлчилгээ (КДИСҮ) гэх Канадын хоёр төрийн бус байгууллагын консорциум юм. MERIT нь Канад Улсын Гадаад хэргийн яамны санхүүжилттэй 7 жил (2016-2023)-ийн хугацаанд хэрэгжих төсөл юм.

### **Канадын мэргэжлийн үйлчилгээний байгууллага (КМҮБ)**

Канадын мэргэжлийн үйлчилгээний байгууллага бол тогтвортой, оролцоог хангасан бизнесийг хөгжүүлэх, төрийн байгуулалтыг бэхжүүлэх замаар олон улсын эдийн засгийн хөгжлийг хурдасгах зорилго бүхий байгууллага юм. Уг байгууллага нь Канад төдийгүй дэлхий даяар өөрийн бизнесийг эхлүүлж, хөгжүүлж байгаа орон нутаг, түнш, засгийн газар, хүмүүст туслуулахын тулд мэргэжилтнүүдийг томилон ажиллуулдаг. 1967 оноос хойш үйл ажиллагаагаа явуулж буй ашгийн бус байгууллага болох КМҮБ-ын мэргэжилтнүүд нь эдийн засаг, нийгэмд өөрчлөлт шинэчлэлийг авчрахын тулд цаг зав, эрч хүчээ зориулдаг сайн дурын зөвлөхүүд байдаг бөгөөд жил бүр 500 гаран тооны томилолтын ажил гүйцэтгэдэг.

КМҮБ нь Канадын Гадаад хэргийн яам, Канадын уугуул иргэд, хойд нутгийн хэрэг эрхэлсэн яам, бусад хувийн хэвшлийн дэмжигчид ([www.ceso-saco.com](http://www.ceso-saco.com) цахим хуудсанд дурдсан)-ийн үзүүлж буй санхүүгийн дэмжлэгт гүнээ талархаж буйгаа энэ дашрамд илэрхийлж байна.

### **Канадын дэлхийн их сургуулийн үйлчилгээ (КДИСҮ)**

Канадын дэлхийн их сургуулийн үйлчилгээ бол дэлхийн залуучуудад боловсрол эзэмших, хөдөлмөр эрхлэх, чадавхжуулах боломж олгоход чиглэсэн ашгийн бус байгууллага юм.

### **Холбоо барих:**

Карин Сэйболд

Харилцааны менежер

416-471-2600

[kseybold@ceso-saco.com](mailto:kseybold@ceso-saco.com)



**CESOSACO**  
STRONGER ECONOMIES. BETTER LIVES.



**WUSC EUMC**



## News Release

болон

**Давид Брэйзо**

Харилцаа, холбоо хариуцсан захирал

416-294-5673

[dbrazeau@ceso-saco.com](mailto:dbrazeau@ceso-saco.com)



**CESOSACO**  
STRONGER ECONOMIES. BETTER LIVES.



**WUSC EUMC**